

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/116/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Audit.mn  
Хэнтий аймаг  
Чингис хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан  
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Платиниум прогресс аудит ХХК аудитор: Б.Дэлгэрмаа  
Утас: 90109012 Цахим хаяг: auditbalance6015@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Харлан сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2026.02.13 № 178

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ М.АРИУНАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 201,449.2 мянган төгрөг, бараа материал 159,826.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 5,483,050.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд улсын төсвөөс 1,242,630.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 233,399.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлого 6,570.0 мянган төгрөгөөр санхүүжиж, 1,453,478.9 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 7,035.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар гурван ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 1,699.4 мянган төгрөгийн цалин, нэг ажилтны ээлжийн амралтын хоногийг 17 хоногоор буюу 2,516.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн үнэлгээний үр

дүнгийн урамшууллыг улиралд олгох хувь хэмжээнээс 2,182.6 мянган төгрөгөөр, анхан шатны баримтгүй 3,424.0 мянган төгрөгийн цалин нийт 9,821.9 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 3,395.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, тайлант онд шилэн дансны нэгдсэн системд 72,721.6 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 4 зорилтын хүрээнд 119 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэл 88.8 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>341,986,106.16</b>	<b>361,275,700.31</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	172,328,285.79	201,449,245.73
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	172,328,285.79	201,449,245.73
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	172,328,285.79	201,449,245.73
31211	Төрийн сангийн харилцах	172,328,285.79	201,449,245.73
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	395,648.59	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	395,648.59	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	50,000.00	-
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	50,000.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	50,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	169,212,171.78	159,826,454.58
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,116,660.00	500,500.00
35110	Тусгай зориулалттай материал	2,116,660.00	500,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	167,095,511.78	159,325,954.58
35410	Бичиг хэргийн материал	2,477,500.00	295,000.00
35420	Аж ахуйн материал	7,270,780.00	2,534,500.00
35450	Барилгын засварын материал	11,841,950.00	3,995,000.00
35460	Хүнсний материал	3,812,990.00	928,630.00
35470	Бусад хангамжийн материал	141,692,291.78	151,572,824.58
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,471,340,357.20</b>	<b>5,483,050,666.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,471,340,357.20	5,483,050,666.74
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,463,122,357.20	5,474,832,666.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,406,608,953.26	5,506,609,942.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,514,939.81)	(261,804,561.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	280,416,878.39	174,483,539.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(161,425,965.48)	(43,039,064.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110,541,172.76	93,551,825.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,008,142.23)	2,856,459.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,974,000.00	3,974,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,819,437.59)	(3,149,312.45)
39217	Ном	1,349,837.90	1,349,837.90
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,218,000.00	8,218,000.00
39301	Програм хангамж	360,000.00	360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(360,000.00)	(360,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,218,000.00	8,218,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,813,326,463.36</b>	<b>5,844,326,367.05</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,886,229.04</b>	<b>80.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,886,229.04	80.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	5,886,229.04	80.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,754,089.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	80.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	132,140.04	-
41361	Байгууллагад төлөх өглөг	132,140.04	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,807,440,234.32</b>	<b>5,844,326,287.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,807,440,234.32	5,844,326,287.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	456,998,392.50	456,998,392.50
51101	Өмч: - төрийн	456,998,392.50	456,998,392.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,335,235,825.44	5,372,121,878.17
51210	Өмнөх үеийн үр дүн	5,335,235,825.44	5,335,235,825.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	36,886,052.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,206,016.38	15,206,016.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,813,326,463.36</b>	<b>5,844,326,367.05</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>6,471,276,836.28</b>	<b>1,656,770,698.33</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,140,746,636.28</b>	<b>173,704,998.33</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,140,746,636.28</b>	<b>173,704,998.33</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,105,391,990.94	167,177,874.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,358,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,100,000.00	6,570,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,102,933,290.94	160,607,874.35
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	35,354,645.34	6,527,123.98
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,330,530,200.00</b>	<b>1,483,065,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,097,665,300.00</b>	<b>1,242,630,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,665,300.00	1,242,630,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>232,864,900.00</b>	<b>240,435,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	232,864,900.00	240,435,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,285,515,311.79</b>	<b>1,619,884,645.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,285,515,311.79</b>	<b>1,619,884,645.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,260,320,567.62</b>	<b>1,584,660,862.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>778,665,163.50</b>	<b>962,035,917.45</b>
210101	Үндсэн цалин	465,135,651.64	881,959,923.64
210102	Нэмэгдэл	268,136,816.46	80,075,993.81
210104	Урамшуулал	45,392,695.40	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>110,867,537.36</b>	<b>119,395,916.72</b>
210201	Тэтгэврийн даатгал	81,223,644.44	82,620,902.56
210202	Тэтгэмжийн даатгал	7,224,639.83	8,976,533.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,837,067.25	4,824,579.60
210204	Ажилгүйдлийн даатгал	3,340,502.23	4,594,780.06
210205	Эрүүл мэндийн даатгал	15,241,683.61	18,379,120.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>197,694,765.83</b>	<b>218,399,232.65</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,450,955.83	24,745,406.65
210302	Түлш, халаалт	183,431,810.00	183,999,976.00
210303	Цэвэр, бохир ус	812,000.00	9,653,850.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,934,690.40</b>	<b>10,447,091.19</b>
210401	Бичиг хэрэг	2,824,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,651,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,432,350.00	-
210408	Бараа материал ақталсны зардал	5,026,840.40	10,447,091.19
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,329,020.00</b>	<b>29,818,250.00</b>
210502	Хоол, хүнс	18,329,020.00	29,818,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,384,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	22,384,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>5,243,423.60</b>	<b>34,140,279.44</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,243,423.60	34,140,279.44
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>105,201,966.93</b>	<b>210,424,174.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,615,422.53	61,595,359.98
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,586,544.40	148,828,814.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,194,744.17</b>	<b>35,223,783.35</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,424,310.00</b>	<b>28,187,916.00</b>
213205	Гөрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,101,630.00	26,894,616.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,322,680.00	1,293,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>770,434.17</b>	<b>7,035,867.35</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлдэг	770,434.17	7,035,867.35
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,185,761,524.49</b>	<b>36,886,052.73</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>5,185,761,524.49</b>	<b>36,886,052.73</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,332,988,900.00</b>	<b>1,489,635,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,458,700.00</b>	<b>6,570,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,458,700.00	6,570,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,458,700.00	6,570,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,358,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,100,000.00	6,570,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>1,330,530,200.00</b>	<b>1,483,065,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,097,665,300.00	1,242,630,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,665,300.00	1,242,630,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	232,864,900.00	240,435,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,864,900.00	240,435,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,237,892,530.66</b>	<b>1,460,514,740.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,237,892,530.66</b>	<b>1,460,514,740.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,212,371,540.49</b>	<b>1,425,344,966.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	784,179,356.82	965,810,457.14
210101	Үндсэн цалин	493,684,962.28	529,098,045.82
210102	Нэмэгдэл	248,901,088.22	364,085,393.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,827,800.00
210104	Урамшуулал	41,593,306.32	44,799,217.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,896,799.04	119,396,117.44
210201	Тэтгэврийн даатгал	68,620,318.33	81,948,477.72
210202	Тэтгэмжийн даатгал	7,681,911.85	9,649,159.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,828,409.32	4,824,579.60
210204	Ажилгүйдлийн даатгал	3,688,097.50	4,594,780.06
210205	Эрүүл мэндийн даатгал	15,078,062.04	18,379,120.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	197,694,765.83	218,399,232.65
210301	Гэрэл, цахилгаан	13,450,955.83	24,745,406.65
210302	Түлш, халаалт	183,431,810.00	183,999,976.00
210303	Цэвэр, бохир ус	812,000.00	9,653,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,002,160.00	26,905,360.00
210502	Хоол, хүнс	18,002,160.00	26,905,360.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,399,700.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	34,399,700.00	15,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,579,982.80	17,090,504.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,022,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,557,282.80	17,090,504.44
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	67,618,776.00	62,743,295.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,348,776.00	57,264,495.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,270,000.00	5,478,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,520,990.17</b>	<b>35,169,773.35</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24,750,556.00	28,133,906.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,725,420.00	25,306,906.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,025,136.00	2,827,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	770,434.17	7,035,867.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	770,434.17	7,035,867.35
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>95,096,369.34</b>	<b>29,120,959.94</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	95,096,369.34	29,120,959.94
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		172,328,285.79
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	172,328,285.79	201,449,245.73

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	456,998,392.50	15,206,016.38	5,335,235,825.44	5,807,440,234.32
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	456,998,392.50	15,206,016.38	5,335,235,825.44	5,807,440,234.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	456,998,392.50	15,206,016.38	5,335,235,825.44	5,807,440,234.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	36,886,052.73	36,886,052.73
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	456,998,392.50	15,206,016.38	5,372,121,878.17	5,844,326,287.05

## 2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,262,219,000.00	1,249,200,600.00
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,262,219,000.00	1,249,200,600.00
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	8,900,000.00	6,570,000.00
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	8,900,000.00	6,570,000.00
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,253,319,000.00	1,242,630,600.00
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,253,319,000.00	1,242,630,600.00
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,343,567,000.00	1,220,079,640.06
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,343,567,000.00	1,220,079,640.06
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,314,606,800.00	1,191,945,734.06
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,066,468,300.00	965,810,457.14
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	605,407,000.00	529,098,045.82
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	413,619,000.00	364,085,393.35
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	-	27,827,800.00
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	47,442,300.00	44,799,217.97
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,805,800.00	119,396,117.44
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	90,988,000.00	81,948,477.72
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	10,704,400.00	9,649,159.39
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	5,352,200.00	4,824,579.60
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	5,352,200.00	4,594,780.06
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	21,409,000.00	18,379,120.67
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	31,492,700.00	26,905,360.00
210502	3.1.01.2.1.1.5.02 Хоол, хүнс	31,492,700.00	26,905,360.00
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,418,900.00	17,090,504.44
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,418,900.00	17,090,504.44
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	65,421,100.00	62,743,295.04
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	59,914,800.00	57,264,495.04
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,506,300.00	5,478,800.00
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,960,200.00	28,133,906.00
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	28,960,200.00	28,133,906.00
213205	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,128,100.00	25,306,906.00
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,832,100.00	2,827,000.00
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(81,348,000.00)	29,120,959.94
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,348,000.00	(29,120,959.94)
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	81,348,000.00	(29,120,959.94)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	172,328,285.79
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	201,449,245.73
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	33	29
620001	6.2.01 Удирдах ажилтан	1	1
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	18	18
620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	14	10

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	240,435,100.00	233,399,232.65
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	240,435,100.00	233,399,232.65
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	240,435,100.00	233,399,232.65
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	240,435,100.00	233,399,232.65
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	240,435,100.00	233,399,232.65
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	240,435,100.00	233,399,232.65
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,435,100.00	233,399,232.65
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,435,100.00	218,399,232.65
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	24,760,900.00	24,745,406.65
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	189,599,900.00	183,999,976.00
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	11,074,300.00	9,653,850.00
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар 85,938.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

Гурван ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 1,699.4 мянган төгрөгийн цалин, нэг ажилтны ээлжийн амралтын хоногийг 17 хоногоор буюу 2,516.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшууллыг улиралд олгох хувь хэмжээнээс 2,182.6 мянган төгрөгөөр, анхан шатны баримтгүй 3,424.0 мянган төгрөгийн цалин нийт 9,821.9 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8."Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

1. Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 3,395.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар "төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" тушаалын "210806-мэдээлэл, технологийн үйлчилгээ-компьютерын хэрэглээний программуудын эрхийн төлбөр, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээг гуравдагч этгээдээс гуравдагч этгээдээс худалдан авах төлбөр энд хамаарна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд 72,721.6 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2 шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### 3.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Аудитаар 13,216.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ээлжийн амралтын олговортой цалин давхардуулсан, анхан шатны баримтгүйгээр нэмэгдэл цалин олгосон	1	9,821.9	1	9,821.9								
Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас худалдан авсан.	1	3,395.0			1	3,395.0						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>13,216.9</b>	<b>1</b>	<b>9,821.9</b>	<b>1</b>	<b>3,395.0</b>						

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн хуулбарын 2 мэдээллийг байршуулаагүй байна.	1	72,721.6			1	72,721.6		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>72,721.6</b>			<b>1</b>	<b>72,721.6</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>72,721.6</b>			<b>1</b>	<b>72,721.6</b>		-

### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			